



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар

1480

Улаанбаатар хот

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Ажлын албаны эргэлтийн бус
Хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 15,360,566.00 (арван таван сая гурван зуун жаран мянга таван зуун жаран зургаа) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (Б.Батбямба)-нд зөвшөөрсүгэй.

2. Татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн 1 нэр төрлийн 4,840,000.00 (дөрвөн сая найман зуун дөчин мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгөх, данснаас хасагдаж буй 7 нэр төрлийн 8,243,946.00 (найман сая хоёр зуун дөчин гурван мянга есөн зуун дөчин зургаа) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтанд дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 1 нэр төрлийн 2,276,620.00 (хоёр сая хоёр зуун далан зургаан мянга зургаан зуун хорь) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 100,000.00 (нэг зуун мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 30,000.00 (гучин мянга) төгрөгийг нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (Б.Батбямба)-нд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В. Оюумаа

Бүтээгдэхүүний үнэ өсөхөд хүргэх үйлдлийн Өмчийн харилцааны газрын 2024 оны дүгээр сарын 1-ний өдрийн дугаар тушаалын хавсгал

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал

[illegible]